



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 82

Номгон

**“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл  
ахуйн” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 зүйлийн 20.1.7, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” үндэсний тав дахь хөтөлбөрийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.


2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж, батлуулан, үр дүнтэй зохион байгуулан, хэрэгжилтийг жил бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын  
07-ны өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт



## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Баянхонгор аймаг 2018 оны байдлаар 87243 хүн амтай, хөдөлмөрийн насны 51215 хүн байгаагийн 74.6 хувь буюу 38235 хүн хөдөлмөр эрхэлж байна. Нийт ажиллагсдын 61.1хувь ХАА-н салбарт, 6.3 хувь боловсролын салбарт, 6.5 хувь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээний салбарт, 4.1 хувь төрийн удирдлага, батлан хамгаалах, 4.0 хувь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт, 3.5 хувь барилгын салбарт, 3.0 хувь боловсруулах аж үйлдвэрийн салбарт, 2.2 хувь эрүүл мэнд, нийгмийн хамгаалах салбарт, 1.8 хувь тээвэр, агуулах, холбооны салбарт, 1.6 хувь нийгэм, бие хүнд үйлчилгээ үзүүлэх салбарт, 1.4 хувь үл хөдлөх хөрөнгө, бизнесийн бусад салбарт, 1.2 хувь зочид буудал, зоогийн газрын салбарт, 1.0 хувь санхүүгийн салбарт, 0.9 хувь цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ажиллаж байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” үндэсний тав дахь хөтөлбөрийг баталсан ба энэ хөтөлбөрт тулгуурлан аймгууд дэд хөтөлбөрөө боловсруулж хэрэгжүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас чиглэл өгсөн.

Монгол Улсын Засгийн газраас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бууруулах зорилгоор 1997 оноос 4 үе шаттайгаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн

Хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд улсын хэмжээнд нийт 1854 үйлдвэрлэлийн осол бүртгэгдэж, 1948 хүн осолд өртөж, 273 хүн амь насаа алдсан бол үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нийт 332 тохиолдол бүртгэгдсэнээс бүлэг осол, хурц хордлого 11 тохиолдол, 2012 онд хөдөлмөр эрхэлж байгаа 10,000 хүнд үйлдвэрлэлийн ослын 3.9 тохиолдол оногдож байсан бол 2016 онд 2.9 болж, нэг пунктээр буурсан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2008, 2015 онуудад 2 удаа аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд 2013-2017 онд 24 осол бүртгэгдснээс эрүүл мэндийн салбарт 2, төрийн байгууллагуудад 15, боловсролын салбарт 3, уул уурхайн салбарт 5 тохиолдол гарч 2 хүн амь насаа алдсан.

Ослуудын шалтгаануудыг авч үзвэл 20.8 хувь аюулгүй ажиллагааны арга барилд хангалтгүй суралцсан, 16.6 хувь хувцас хэрэгсэл олгоогүй, 41.6 хувь тоног төхөөрөмжийн аюулгүй байдал алдагдсан, 16.6 хувь анхаарал болгоомжгүй ажилласнаас болж гарсан байна.

Хөтөлбөр хэрэгжсэнээр аймагт төр, ажил олгогч, Үйлдвэрчний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл ажиллаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд удирдлага арга зүйгээр хангах, хяналт тавих, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан ба аймагт Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлтэй 77 байгууллага, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэдэг байнгын комисстой 20 байгууллага, ХАБЭА асуудал хариуцсан 49 ажилтан байгаагийн орон тооных 20 ажилтан ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М.Даваабат нар Баянхонгор аймгийг “Эрүүл аюулгүй ажлын байрыг Эрхэмлэгч аймаг” болгох чиглэлээр хамтран ажиллах 2 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрх зүйн орчин бүрдсэн ч аж ахуйн нэгж байгууллага мөрдөж ажиллахгүй байх, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс талаарх мэдлэг хангалтгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал хангалтгүй, хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо муу, санхүүжилтгүй, хариуцлага тооцдоггүй зэрэг тулгамдсан асуудал байсаар байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг сайжруулах, аж ахуйн нэгж байгууллагын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн ажлыг чадваржуулах, барилга, уул уурхай зэрэг шаардлагатай аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны ажилтанг тогтвортой мэргэшүүлэн ажиллуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр аймгийн хэмжээнд хийгдсэн нэгдсэн судалгаатай болох, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх, аж ахуйн нэгж байгууллагууд ажиллагсдынхаа хөдөлмөрлөх эрх, ажлын байрны эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, хяналт тавих, ажлыг уялдааг хангах зэрэг асуудлыг шийдвэрлэдэг болох зэрэг нь хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага болж байна.

### ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Хөтөлбөрийн зорилго: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хууль эрх зүйн хэрэгжилтийг сайжруулж, эрсдэлгүй, аюулгүй, эрүүл ажлын байрны орчинг бүрдүүлэх, ажиллагчдад аюулгүй ажиллах зан үйл, соёлыг төлөвшүүлэх, удирдлагын тогтолцоо, чадавхыг бэхжүүлэх замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх эрхийг хангуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бууруулахад оршино

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 2.2.1.Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- 2.2.2.Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
- 2.2.3.Оролцоо, санаачилга, мэргэжлийн хандлагад тулгуурлах
- 2.2.4.Нийгмийн хариуцлагатай хандах
- 2.2.5.Нийгмийн түншлэлийг эрхэмлэх
- 2.2.6.Ил тод байх
- 2.2.7.Эрсдэл өндөртэй салбарт түлхүү анхаарах

### ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮН, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж стандартыг аж ахуй нэгж, байгууллага ажлын байранд мөрдүүлж хэвшүүлэх

Хүрэх үр дүн: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт сайжирч, зөрчил буурч, стандартын шаардлага хангасан ажлын байрны тоо нэмэгдсэн байна.

Зорилт 1-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомж, стандартыг сум, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд нийгмийн түншлэгч талуудын оролцоотойгоор мөрдүүлж хэвшүүлэх төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэх

1.2. Аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэлийн горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчихгүй байхыг сануулсан тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулга, сэрэмжлүүлэг хэрэглэж хэвшүүлэх

1.3. Хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл эрхлэж байгаа аж ахуй нэгжээс оршин суугч иргэдийн аж амьдрал, эрүүл мэндэд учруулж байгаа хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг сумын гурван талт хэлэлцээрт тусгуулах

1.4. Уул уурхайн компаниудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөл, байдалд аймгийн холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг зохион байгуулах

1.5. Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах

Зорилт.2 Хөтөлбөрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хяналтын үр нөлөөтэй арга хэлбэрийг төлөвшүүлэх

Хүрэх үр дүн: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж төлөвшсөн байна.

Зорилт 2-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлж, чиглэл, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

2.2. Ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан сумын болон аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах арга хэмжээг авах

2.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандартыг аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрүүлэх, удирдлагаар хангах, арга зүйн зөвлөмж гаргах

2.5. Барилга, уур уурхай, дулаан түгээх, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын 40-с доошгүй хувийг ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээнд хамруулж, ажлын байрны эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах талаар зөвлөмж өгөх, үр дүнг тооцох

2.6. Аймаг, сум, аж ахуйн нэгж байгууллагуудын ХАБЭА-н итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжинд тавих хяналт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх

2.7. Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооноос анхан шатны ҮЭ-ийн бүх нэгжүүдэд Хөдөлмөрийн болон ХАБЭА-н үзлэгийг гишүүд, идэвхтэн

сонгуультануудын оролцоотойгоор жил бүр хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажил зохиох

2.8. Баянхонгор аймгийн “ХАБЭА зөвлөл”-ийг улсын хэмжээнд загвар зөвлөл болгоход дэмжлэг үзүүлэх

2.9. ХАБЭА асуудал хариуцсан 200 ажилтныг мэргэшүүлэх сургалтанд хамруулж мэргэшсэн “ХАБЭА ажилтан” бэлтгэх

Зорилт.3 Хөтөлбөрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд шинэлэг, үр нөлөөтэй арга хэлбэрээр тогтмол зохион байгуулж, “Эрүүл аюулгүй ажлын байрыг Эрхэмлэгч аймаг” болох

Хүрэх үр дүн: Иргэн бүр урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар, дадалтай болж, эрүүл, аюулгүй ажлын байрууд бий болж “Эрүүл аюулгүй ажлын байрыг Эрхэмлэгч аймаг” болох зорилго биелэнэ.

Зорилт 3-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцан зохион байгуулж хэвшүүлэх

3.2. Нийт иргэдэд эрүүл, аюулгүй ажиллаж амьдрах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад хэвлэл мэдээллийн байгууллагыг оролцуулах боломж, нөхцөлөөр хангах;

3.3. Ажлын байран дахь асбесттай холбоотой өвчний оношлогоо, бүртгэл, тандалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах;

3.4. Аж ахуй нэгж, байгууллагын мөрдөж байгаа дүрэм, журмыг ойлгомжтой хялбар болгон ажилчдад хүргэх, ажлын байран дээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих.

3.5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг явуулын хэлбэрээр зохион байгуулах ажлыг мэргэшсэн сургалтын болон төрийн бус байгууллагатай хамтран үе шаттай зохион байгуулах.

3.6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх үйл ажиллагааг боловсронгуй болгож, мэдээллийн нэгдсэн сантай болох замаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний талаар статистик мэдээллийг сайжруулах

3.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшүүлэх, давтан, "POSITIVE" сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

3.8. Аймгийн "ХАБЭА-г эрхэмлэгч байгууллага" шалгаруулах уралдааныг болзол гарган сурталчлан, хэрэгжүүлж, дүгнэн урамшуулан загвар аж ахуйн нэгжүүдийг бий болгох

3.9. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр"-ийг бүх нийтээр тэмдэглэх, аж ахуй нэгж байгууллага бүр энэ өдөр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн ослоор нас барагсдын дурсгалыг хүндэтгэх тал бүрийн үйл ажиллагааг зохион байгуулж хэвших.

3.10. Барилга, уул уурхай салбарын үндэсний шилдэг байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлыг үе шаттай зохион байгуулах

3.11. Жил бүр аймгийн Засаг даргын нэрэмжит "Эрсдэлгүй, эрүүл ажлын байрыг бий болгоцгоо" үзлэгийг зохион байгуулж, үр дүнг тооцох

Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахад ажил олгогчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажилтнууд аюул эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зөв хандлагыг төлөвшүүлэх

Хүрэх үр дүн: Аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн заалтыг мөрдөн хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа өөрчлөлт гаргаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтэц, орон тоог бий болгосноор ажил олгогчийн үүрэг хариуцлага дээшилж, ажилтнуудын аюулгүй ажиллагааны соёл, зөв хандлага төлөвшсөн байна.

Зорилт 4-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Аж ахуйн нэгж, байгууллагууд "Ослыг тэглэх, осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө" боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж хэвших;

4.2. Ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, дохио, санамж, анхааруулга, тэмдэг тэмдэглэгээ тавьж, хаалт хамгаалалтыг бүрэн хийж хэвшихэд ажил олгогч бүр санаачилгатай хандаж, аюулгүй орчинг бүрдүүлэх;

4.3. Аж ахуйн нэгж, байгууллага бүр ажилтнуудыг шаардлага хангасан ахуйн байраар хангах, алжаал /стресс, сэтгэлийн хямрал/ тайлах, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх өрөө танхимтай болох хөдөлгөөн өрнүүлэх;

4.4. Аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба, ажилтныг орон тоо, бүтцээр ажиллуулах, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж, гишүүдийг дадлагажуулах, чадавхижуулах ажлыг зохион байгуулах;

4.5. Ажил олгогч ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах зэрэг асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлж байх

4.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажилтан бүрт ойлгомжтой, энгийн, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шилдэг арга барил, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх, бусдаас харилцан суралцах ажлыг зохион байгуулах

4.7. Аймгийн Засаг дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, уул, уурхайн компаниудын эзэд /захирал/-тэй “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг эрхэмлэгч байгууллага болгох” гурвалсан гэрээ байгуулсан гэрээг хэрэгжүүлж, загвар аж ахуйн нэгжүүдийг бий болгох

4.8. Барилга, уул уурхайн салбарын үндэсний шилдэг байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлыг үе шаттай зохион байгуулах

4.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 зүйлийн 26.2-т заасан “Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.” заалтыг үр дүнгийн болон бусад гэрээндээ заавал тусгаж хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Зорилт. 5 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, оношлогоо, үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулах

Хүрэх үр дүн: Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, үйлдвэрлэлийн осол,



мэргэжлээс шалтгаалсан өвчинд өртсөн ажилчдад үзүүлэх эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

Зорилт 5-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.1, 14.2-т зааснаар аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдыг жилд 1-2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах

5.2. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн чадвар алдалтын байдлын судалгааг салбар тус бүрээр гаргуулж, аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, чадавх бий болгох, дадлага эзэмшүүлэхэд туслах

5.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдсан ажилтанд үзүүлэх эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

### ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

#### ХУГАЦАА, УДИРДЛАГА

4.1. Хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг холбогдох байгууллага үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлнэ. Хэрэгжилтийн талаарх тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 05-ны дотор Хөдөлмөр халамжийн үйлчигээний газарт ирүүлнэ.

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газар аймаг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулна. Сумдын Засаг даргын тамгын газар, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага энэ хөтөлбөрийн хүрээнд өөрт хамаарах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

4.4. Аж ахуйн нэгж, байгууллага бүр энэхүү хөтөлбөрт тусгагдсан холбогдох асуудлыг жил бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг зохион байгуулна.

#### ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

5.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

5.1.2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас энэ зориулалтаар гаргах хөрөнгө;

5.1.3. Хамтын ажиллагаатай гадаад орон, олон улсын байгууллагаас энэ чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн санхүүжилт, буцалтгүй тусламж

5.1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулах хөрөнгө

5.1.5. Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө

5.1.6. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив.

5.1.7. бусад эх үүсвэр.

### ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

6.1. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ажилтны болон ажил олгогчийн төлөөллийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг аймгийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ил тод, нээлттэй мэдээлнэ.

6.3. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан хяналт шинжилгээний ажлын хэсэг жил бүр Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын 2018 оны 79 дүгээр захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ.

6.4 Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 01 сарын 10-ны дотор гаргаж, үндэсний хөтөлбөрийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамд хүргүүлэх ба дэд хөтөлбөрийн тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнана.

### ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, БҮТЭЭГДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он 2017	Зорилтот түвшин, он			Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллага
				2018	2019	2020		
<b>Нэг. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар:</b>								
1.1	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо*	/10.000 ажиллагчдад ногдох/	1,24	1,23	1,22	1,21	МХГ	МХГ ХХҮГ
1.2	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас нас барсан хүн*	/10.000 ажиллагчдад ногдох/	0.4	0.4	0.4	0.3	МХГ	МХГ ХХҮГ
<b>Хоёр.Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллага</b>								
2.1	Хөдөлмөрийн хяналт	тоо	30	30	30	30	МХГ	МХГ
2.2	Сургалт	ажилтны тоо	800	850	900	1000	ХХҮГ	ХХҮГ

Гурав. “Эрүүл аюулгүй ажлын байрыг Эрхэмлэгч аймаг” болох								
3.1	“Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч” байгууллага	Байгууллагын тоо	5	8	11	13	ХАБЭА салбар зөвлөл	МХГ ХХҮГ Байгууллага уд
3.2	ХАБЭА үзлэг зохион байгуулна	Үзлэгийн тоо	3	3	5	8	Салбар зөвлөлийн тайлан	ХАБЭА салбар зөвлөл
3.3	ХАБЭА болон ҮОХХМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хөрөнгө тусгасан байгууллага /хууль 26.2 заалт/	Хөрөнгө тусгасан байгууллага	12	15	30	60	Салбар зөвлөлийн тайлан	ХАБЭА салбар зөвлөл
3.4	ХАБЭА дэд хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө	Хөрөнгө /сая төг/	1.8	8.0	10.0	15.0	Салбар зөвлөлийн тайлан	ХАБЭА салбар зөвлөл

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_